

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Хүнс, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, Цэнддорж Ганхуяг
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	
1.1. Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг орон нутгийн үйлдвэрлэлээр хангана.							
1	Нөөцийн мах худалдаанд гарах бэлтгэл ажлыг зохион байгуулах, борлуулалтад хяналт тавьж ажиллах	Хаврын хэрэгцээт махны хувь, бэлтгэсэн мах /тн/	-	-	Аймгийн хүн амын 2024 оны хаврын махны хэрэгцээний 21.6 хувь буюу 200 тн махыг Эрдмийт ХХК, Жаргалант мах импекс ХХК-иуд бэлтгэн нийлүүлсэн. 3 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн 6 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл хугацаанд Баян-Өндөр сумын 17 багийн 29 цэг, Жаргалант суманд 2 нийт 31 цэгээр ангилан савласан ястай үхрийн мах 1 кг нь 9000, хонины мах 1 кг нь 6400, ямааны мах 1 кг нь 4900 төгрөгийн үнээр хэрэглэгчдэд худалдаалж, хаврын улиралд махны нийлүүлэлтийг нэмэгдүүлэн ажилласан. Үр дүнд хэрэглэгчдэд үхрийн мах 7800, хонины мах 8300, ямааны мах 5500 төгрөгийн хямд үнэтэй хүргэсэн. Аймгийн Засаг	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар	100%

					даргын 2023 оны А/681 дүгээр захирамжаар нөөцийн махны бэлтгэл, хадгалалт, ангилан савлалт, борлуулалт, хүртээмжийн байдалд хяналт хийх ажлын хэсгийг байгуулсан. Аймгийн Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлого, хөрөнгө оруулалтын хэлтэс, Хэвлэл мэдээллийн алба, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газар, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, сумдын Засаг даргын тамгын газар, Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг хамтран нэгдсэн хяналтыг 5, хяналт хийх байгууллагууд 21, нийт 25 удаагийн хяналтыг хийж, махны нийлүүлэлт удаашралтай байгаа талаарх мах худалдан борлуулж буй дэлгүүрүүдээс ирүүлсэн 12 саналыг шийдвэрлүүлэн ажилласан.		
2	Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг дэмжин ажиллах, бүтээгдэхүүний нэр, төрлийг нэмэгдүүлэх	Дэмжлэгт хамрагдсан үйлдвэрлэгчийн тоо, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлтийн өсөлтийн тоо хэмжээ	Хүнсний боловсруулах үйлдвэрлэл, худалдааны салбарын чиглэлээр давхардсан тоогоор 16 аж ахуйн нэгж, байгууллага, 15 иргэн 3.3 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл, дэмжлэгт хамрагдан үйл ажиллагаагаа өргөжүүлснээр аймгийн боловсруулах салбарын үйлдвэрлэлтийн 18.6 хувийг хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлт эзэлж, 37.1 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж,	Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг төсөл, хөтөлбөрт хамрагдахад арга зүйн зөвлөгөө өгч, дэмжин хамруулах	Хүнс, хөдөө аж ахуйн хүүгийн хөнгөлөлттэй зээлээс хиам, талх үйлдвэрлэлийн 2 аж ахуйн нэгж 900.0 сая төгрөг, Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас нарийн боов, бялууны бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 2 аж ахуйн нэгж 277.0 сая төгрөгийн зээл тус тус авч, бялуун төрлийн бүтээгдэхүүний 1 аж ахуйн нэгж шинээр нэмэгдэж, 10 сарын байдлаар 26 үйлдвэр статистик мэдээнд хамрагдаж, 27.4 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 28.7 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүний борлуулалтыг хийж, 2275 тн мах, махан бүтээгдэхүүн, сүү 343.9 мян.л, тараг 23 мян.л, зайрмаг 468.0 мян.ш,	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

			47.9 тэрбум төгрөгийн борлуулалт хийж, өмнөх оны мөн үеэс үйлдвэрлэлт 32.9, борлуулалт 64.0 хувиар тус тус өссөн байна.		гурил 93.1 тн, гурилан бүтээгдэхүүн 2743.3 тн, савласан цэвэр ус 2572.3 мян.л, жүүс 11.1 мян.литр буюу 8 нэрийн 21 төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн 346.4 тн хохины махыг Иран улсад экспортлож, хохины мах 46.4, хиам 4.9, нарийн боов 5.9, хэвийн боов 89.9, талх 52.9, савласан цэвэр ус 52 хувиар, сүү 2.0, зайрмаг 2.1, жүүс 4.6 дахин үйлдвэрлэл өссөн.		
3	Орон нутгийн хүнсний үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа, бүтээгдэхүүнийг дэмжин сурталчилах, борлуулалтын сувгийг нэмэгдүүлэх	Борлуулалтын сувгийг нэмэгдүүлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, хамруулсан бизнес эрхлэгчийн тоо	"Намрын ногоон өдрүүд-Үндэсний үйлдвэрлэл-2023" улсын нэгдсэн арга хэмжээнд хүнс, газар тариалан, хөнгөн үйлдвэрийн салбарын нийт 13 үйлдвэрлэгч оролцож, 38.0 сая төгрөгийн борлуулалтыг хийсэн	"Намрын ногоон өдрүүд-2024" нэгдсэн арга хэмжээнд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин оролцуулна	Best хөтөлбөр, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГазрын Худалдан авах ажиллагааны газартай хамтран 22 хүнсний үйлдвэрлэл эрхлэгчийг хамруулан уулзалт зохион байгуулж, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн талаарх танилцуулга мэдээллийг өгч, хэрхэн бараа, бүтээгдэхүүнээ үйлдвэрт нийлүүлэх боломжийн талаарх зөвлөгөө мэдээллээр хангасан. Үүний дүнд 2 аж ахуйн нэгж Эрдэнэт үйлдвэрт сүү, тараг, чацарганы жүүсийг холбогдох стандартын шаардлагыг ханган нийлүүлж байна. ХХААХҮЯамнаас зохион байгуулсан "Намрын ногоон өдрүүд-Үндэсний үйлдвэрлэл -2024" үзэсгэлэн худалдаанд хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр Хантай баян ХХК халтар арвайн гурил, Ачит андага ХХК артишок цай, 2 төрлийн жүүс, артишок шимийн архи, Баярмөнх наран ХХК эрүүл мэндийн цай, Эрдэнэт ногоон нүүдэл ХХК грек бяслаг, шар сүүний цэлцэгнүүр, тус	2-р сар, 3-р сар, 9-р сар, 10-р сар	100%

					компанитай хамтран ажиллагч 1 малчин уламжлалт аргаар бэлтгэсэн цагаан идээ, газар тариалангийн чиглэлээр Жаргалант, Баян-Өндөр сумын сумын 6 тариаланч 11 төрлийн 20 тн төмс, хүнсний ногоогоор оролцож, нийт 23.0 сая төгрөгийн борлуулалтыг хийсэн.		
4	УИХ-ын 2022 оны 36 дугаар тогтоолын хүрээнд хүнсний боловсруулах үйлдвэрт олгосон зээлийн хэрэгжилтэд хяналт тавих	Нийт зээлдэгчийг хамруулсан хувь	-	Хяналт тавих ажлыг зохион байгуулж, үр дүнг тайлагнана	2023 онд Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөлөлттэй зээлээс талх, нарийн боовны 3, мах махан бүтээгдэхүүний 2, эрүүл мэндийн цайны 1 буюу нийт 6 аж ахуйн нэгж хамрагдаж, эргэлтийн хөрөнгийн 521.0 сая төгрөг, хөрөнгө оруулалтын 438.2 сая төгрөгийн зээл авсан. 2024 онд Хүнс, хөдөө аж ахуйн хүүгийн хөнгөлөлттэй зээлээс хиам, талх үйлдвэрлэлийн 2 аж ахуйн нэгж 900.0 сая төгрөг, Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас нарийн боов, бялууны бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 2 аж ахуйн нэгж 277.0 сая төгрөгийн зээл тус тус авч, бялуун төрлийн бүтээгдэхүүний 1 аж ахуйн нэгж шинээр нэмэгдсэн. Зээлийн үр дүнд хяналт хийж ажиллалахад талхны хагас автомат үргэлжилсэн үйл ажиллагаатай тоног төхөөрөмжийн шинэчлэл хийгдэж, хүчин чадал 20 хувиар нэмэгдэж, талх, нарийн боовны нэр төрөл 5-аар, мах хадгалах зоорийн хүчин чадлыг 30 тн-оор нэмэгдсэн. 10 сарын байдлаар 27.4 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 28.7 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүний борлуулалтыг хийж, 2275 тн мах, махан бүтээгдэхүүн, сүү	2-р сар, 3-р сар, 4-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар	100%

					343.9 мян.л, тараг 23 мян.л, зайрмаг 468.0 мян.ш, гурил 93.1 тн, гурилан бүтээгдэхүүн 2743.3 тн, савласан цэвэр ус 2572.3 мян.л, жүүс 11.1 мян.литр буюу 8 нэрийн 21 төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн 346.4 тн хонины махыг Иран улсад экспортлож, хонины мах 46.4, хиам 4.9, нарийн боов 5.9, хэвийн боов 89.9, талх 52.9, савласан цэвэр ус 52 хувиар, сүү 2.0, зайрмаг 2.1, жүүс 4.6 дахин үйлдвэрлэл өссөн үр дүнтэй.		
5	Үйлдвэрийн аргаар боловсруулсан сүүний хэмжээг нэмэгдүүлэх	Сүүний урамшуулалд хамрагдсан үйлдвэр, малчин, фермерийн тоо, бүтээгдэхүүний үйлдвэрлэлтийн өсөлт	"Баяжуулагч одод" ХХК-ийн сүүний үйлдвэрт 2022 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 3 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд 50 малчин, фермер 47451 литр сүү нийлүүлж, 23.7 сая төгрөгийн урамшуулал олгогдсон.	Сүү боловсруулах үйлдвэрийн сонгон шалгаруулалтад аж ахуйн нэгжүүдийн материалыг журмын дагуу бүрдүүлж, хугацаанд нь хүргүүлэх ажлыг зохион байгуулна.	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 130 дугаар тогтоолын хүрээнд 2023 оны 11 сарын 1 ний өдрөөс 2024 оны 03 сарын 31 ний өдрийг дуустал хугацаанд малчид, фермерүүдээс малын шингэн сүү хүлээн авах үйлдвэрийн сонгон шалгаруулалтад Баяжуулагч одод ХХК, Эрдэнэт Хаан Сүү ХХК-ийн сүү боловсруулах үйлдвэрүүд шалгарч, 2 аж ахуйн нэгж, 35 малчид, фермерээс 345.0 мянган литр сүү хүлээн авч, үйлдвэрт боловсруулсан байна. Үр дүнд 2024 оны 10 сарын байдлаар өмнөх оны мөн үеэс шингэн сүү үйлдвэрлэлт 2 дахин, зайрмаг 2.1 дахин нэмэгдэж, физиологийн хэрэгцээт сүүний 8.3, сүүн бүтээгдэхүүний 7.1 хувийг үйлдвэрийн аргаар боловсруулсан бүтээгдэхүүнээр хангаж байна. Харин 2024 оны 11 сарын 1 ний өдрөөс 2025 оны 03 сарын 31 ний өдрийг дуустал хугацаанд сүү хүлээн авах үйлдвэрээр Сүү ХК, Баяжуулагч одод ХХК-иуд шалгарсан.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

1.2. Хүн амын хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлнэ.

6	Орон нутгийн онцлогтой хоол, идээ ундааг хөгжүүлэх, сурталчилах, түгээн дэлгэрүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулах	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	Орон нутгийн онцлогтой хоол, идээ ундааг хөгжүүлэх, сурталчилах хүрээнд аймгийн аварга тогооч, зөөгч шалгаруулах ур чадварын уралдаан-1, Төв, Хангайн бүсийн аварга тогооч, зөөгч шалгаруулах ур чадварын уралдаан-1, захирамжийн сургалт-1, гэрээгээр хийсэн сургалт-1 буюу нийт 2 удаагийн уралдаан, 2 удаагийн сургалт зохион байгуулсан.	1 удаагийн арга хэмжээ зохион байгуулна.	Орхон аймгийн Тогоочдын холбоотой хамтран 1 удаагийн 2 арга хэмжээ, 1 удаагийн мэргэшүүлэх сургалт нийт 3 арга хэмжээг зохион байгуулсан. Аймгийн Засаг даргын Тамгын газар, Монголын Тогооч нарын холбоо, Орхон аймгийн Тогоочдын холбоо, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-тай хамтран Монгол үндэсний хоол, идээ ундааны "Улсын аварга тогооч" шалгаруулах анхдугаар уралдааныг 7 төрөлд, Монголын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын ажиллагсдын спортын анхдугаар наадмыг 5 төрөлд явуулж, 18 аймаг, 7 дүүргийн нийт 700 гаруй салбарын ажиллагсад оролцож, 58 шагналт байрыг эзлүүлэн шагнаж урамшуулсан. Үр дүнд орон нутаг анх удаа тогооч нарын улсын зэрэглэлтэй арга хэмжээг амжилттай зохион байгуулж, 426 тогоочийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэн харилцан туршлага судлуулсан. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Сургалт, үнэлгээ судалгааны институтын "Мэргэжлийн түвшин тогтоох чадамжийн АРР" үнэлгээ олгох 14 хоногийн сургалтыг зохион байгуулж, нийт 35 тогоочийг хамруулсан.	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар	100%
7	Хүнс, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг чадавхижуулах сургалтуудыг үе	Зохион байгуулсан сургалтын тоо	8 удаагийн сургалт зохион байгуулсан	1 удаагийн сургалт зохион байгуулна.	Хүнс, хоол үйлдвэрлэлийн салбарын хууль, эрх зүйн болон технологийн мэдлэгийг бататгах, дээшлүүлэх зорилгоор сургалтуудыг үе шаттай зохион байгуулсан. Сургалтыг Монголын Хүнсчдийн холбоо, Орхон	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар	100%

	шаттай байгуулах	зохион			аймгийн тогоочдын холбоо, Хөгжлийн шийдэл ТББ-аас хэрэгжүүлж буй Best хөтөлбөртэй хамтран нийт 5 удаагийн сургалтад хүнсний үйлдвэрлэл, хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхлэгч 425 төлөөллийг хамруулсан. Үр дүн: Хоол үйлдвэрлэлийн 35 тогоочийг мэргэшүүлэх үнэлгээний сургалтад амжилттай хамруулж, сүү, сүүн бүтээгдэхүүн, талх, нарийн боовны үйлдвэрлэлд зохистой дадал нэвтрүүлэх, технологийн карт зохиох, мөрдөх технологийн мэдлэг олгон чадавхжуулав.	10-р сар	
8	Хүнсний үйлдвэр, цех, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллага, хүний нөөцийн судалгааг салбар тус бүрээр шинэчлэн гаргах	Шинэчилсэн судалгааны тоо	2023 оны 2 сарын байдлаар хүнс, хоол үйлдвэрлэлийн салбарын судалгааг шинэчлэн гаргасан.	Нэмэлт баяжуулалт хийсэн байна.	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй хүнсний үйлдвэр, цех болон хоол үйлдвэрлэл эрхлэгчдийн судалгааг шинэчлэн гаргаж, ХХААХҮЯаманд цахимаар хүргүүлэн ажиллав. Хүнсний чиглэлээр 125 үйлдвэр, цех ажиллаж байгаагаас хуулийн этгээдийн бүртгэлтэй 55, иргэнээр 70 байна. Эдгээрээс 26 үйлдвэр статистик мэдээнд тогтвортой хамрагдаж, 33 нь байнгын бус үйл ажиллагаатай байна. Тэдгээрт нийт 1021 хүн ажиллаж байгаагийн 357 хүн мэргэжлийн бол инженер, технологич, талх, нарийн боов, хими чиглэлийн мэргэжилтэй боловсон хүчний нөөц дутмаг энэ чиглэлийн 426 мэргэжилтэн шаардлагатай байна. Хоол үйлдвэрлэлийн чиглэлээр нийт 262 цэг, салбар үйл ажиллагаа явуулж, тэдгээрт 1452 ажиллагсад ажиллаж байгаагийн 508 нь мэргэжлийн бол шаардлагатай байгаа хоол зүйч,	2-р сар, 3-р сар, 10-р сар	100%

					тогооч, бэйкери-нарийн боовны тогооч, үйлчлэгч, зөөгчийн тоо 485 байна.		
2.1. Хүн амын хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлнэ.							
9	"Хүнсний аюулгүй байдлын цаг" булан, нэвтрүүлгийг тогтмол явуулж, ард иргэдийг хоол, хүнсний зөв зохистой хэрэглээнд төлөвшүүлэх, орон нутгийн үйлдвэрлэгчдийн үйл ажиллагааг нийтэд таниулах	Бэлтгэн нийтлэсэн нэвтрүүлгийн тоо	Номин телевизтэй 2023 онд хамтран ажиллах гэрээ байгуулж, "Хүнсний аюулгүй байдлын цаг" тусгай хөтөлбөрт сард 3 удаа буюу нийт 25 удаагийн тус бүр 5 минутын мэдээлэл, 2 удаагийн нэвтрүүлэг бэлтгэн хэрэглэгчдэд хүргэсэн. Хүнсний зөв хэрэглээ, хадгалалт, худалдан авалт болон сонголтын чиглэлээр анхаарах асуудлын талаар 9 постер, 4 богино хэмжээний бичлэг, 5 төрлийн гарын авлага гаргаж, Хүнс, хөдөө аж ахуйн пэйж хуудсанд давтамжтайгаар байршуулж, хэрэглэгчийн боловсролыг дээшлүүлэв.	Нэвтрүүлгийг тогтмол явуулж хэвшин, үр дүнг тайлагнана	Нөөцийн махны чанар, эрүүл ахуйн тухай ойлголт, бэлтгэл, хадгалалтын горим, нөхцөл, тээвэрлэлт, худалдан борлуулах цэгийн байршил, үнийн талаарх мэдээлэл, явцын тухай нийт 2 удаагийн нэвтрүүлэг, 1 постер, 1 шторкийг бэлтгэн байгууллагын фэйж хуудас, аймгийн Засаг даргын тамгын газрын хэвлэл мэдээллийн албаар дамжуулан олон нийтэд мэдээлж ажилласан. Үр дүнд хэрэглэгчид нөөцийн махны үнэ, байршил, махны чанарын талаарх нэгдсэн ойлголтыг авч, нөөцийн махтай холбоотой санал, шүүмжлэл өмнөх оны мөн үеэс 90 хувиар буурч, хэрэглээнд нөлөөлсөн.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
3.1. Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах							
10	ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль	Батлагдсан төлөвлөгөө, тайлагналтын тоо	Гүйцэтгэлийн төлөвлөгөө болон салбарын чиглэлээр батлагдсан бодлогын баримт бичиг болон хууль тогтоомжийн биелэлтийг цаг хугацаанд нь гарган тайлагнаж ажилласан.	Гүйцэтгэлийн төлөвлөгөө болон бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилти	Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг сар, хагас, бүтэн жилээр гарган тайлагнан ажиллав. Аймгийн ИТХурлын Тэргүүлэгчдийн 2022 оны 12/02 дугаар тогтоолоор батлагдсан "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар,	100%

	тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх			йг тайлагнан ажиллана.	хөдөлгөөнийг Орхон аймагт хэрэгжүүлэх 2022-2027 оны төлөвлөгөөний 2024 оны хэрэгжилтийг ирэх оны эхний улиралд хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.	11-р сар, 12-р сар	
11	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх	Хууль, эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийг тайлагналт	Хууль, эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийг ханган ажилласан.	Хууль, эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийг ханган ажиллаж, тайлагнана	Албан хэрэг хөтлөлт, Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албан нийтийн болон хувийн ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх тухай хууль тэдгээртэй нийцүүлэн гаргасан журмын хэрэгжилтийг ханган ажиллав. 2024 оны хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах болон байгууллагын нийт албан хаагчдад авлига ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх мэдлэг олгох сургалтыг аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтран зохион байгуулж, нийт албан хаагчдын 90.4 хувь буюу үйлчлэгч, жолоочоос бусад 19 албан хаагчийг хамруулсан. Мөн Авлигатай тэмцэх газраас хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтны жагсаалтад өөрчлөлт орохтой холбогдуулан зохион байгуулсан цахим сургалтад нийт 18 албан хаагч хамрагдсан. Сургалтын үр дүнд хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах арга зүйд суралцан 2024 онд нийт албан хаагчид ашиг сонирхлын зөрчилгүй ажилласан. "Төрийн албан	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					хаагчийн ёс зүйн тухай хууль” батлагдсантай холбогдуулан байгууллагын албан хаагчдад ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хууль танилцуулах, ажлын байрны зөөлөн ур чадвар ба байгууллагын соёлын чиглэлээр соён гэгээрүүлэх сургалтыг “Байгууллагын сургалтын лаб” төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулсан. Сургалтад нийт албан хаагчдын 90.4 хувь буюу 19 албан хаагчийг хамруулан байгууллагын соёлын үндсэн ойлголт, орчин цагийн чиг хандлага, оролцогч талуудын эрх үүрэг, оновчтой удирдах, хэрхэн оролцох болон байгууллагын соёлд ажлын байрны зөөлөн ур чадварын хамаарлын талаарх онолын мэдлэгийг олгосноор төрийн албан хаагчтай холбоотой ёс зүй, харилцаа хандлагын зөрчил бүртгэгдээгүй. Байгууллагын албан ёсны hhaag.erdenet.mn цахим хаягт ёс зүйн дэд хорооны талаарх цэс, facebook пэйж хуудас, ёс зүйн самбарт хэрэгжүүлж буй ажил, мэдээ, мэдээллийг нийтлэн байршуулж, албан хаагч, иргэд мэдээллээр хангагдах боломжийг бүрдүүлсэн.		
--	--	--	--	--	---	--	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан	Биелэлтийн

	1	2	3	4	5	хугаца	хувь
						6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Салбарын чиглэлээр мэдлэг дээшлүүлэх сургалт, арга хэмжээнд хамрагдах	Салбарын чиглэлээр мэдлэг дээшлүүлэх сургалт, арга хэмжээнд 2 оос доошгүй удаа хамрагдах	1 удаагийн сургалтад хамрагдсан.	1 удаагийн арга хэмжээнд хамрагдана.	Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалтын хэрэгжилтийг хангах хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Монголын махны холбоотой хамтран зохион байгуулсан "Мах, дотор махны өртгийн сүлжээг бэхжүүлэхэд мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалт, технологийн хяналтын үүрэг" сэдэвт танхимын болон дадлага сургалтад энэ оны 09 дүгээр сарын 24, 25 ны өдрүүдэд хамрагдан оролцсон.	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Хүнс, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, Цэнддорж Ганхуяг /...../

Огноо: 2024.12.05